



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 1111

Чингис хот

“Тэмүүжин хороолол” амины орон сууцны
хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4д, “Хот байгуулалтын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, “Барилгын тухай” хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дах заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын 3-р багт хэрэгжиж буй “Тэмүүжин хороолол” амины орон сууцны хорооллыг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах эрх бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------------|----------------|--|
| Ажлын хэсгийн дарга: | Ц.Чогсомжав | Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга: | Э.Мөнх-Эрдэнэ | ЗДТГазрын ХОХБТХэлтсийн дарга |
| Гишүүд: | М.Шүрэнцэцэг | Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч |
| | С.Нямдаваа | ЗДТГазрын СТСХэлтсийн дарга |
| | Н.Дарханбаатар | ЗДТГазрын ХЭХэлтсийн дарга |
| | С.Лхагвачулуун | ЗДТГазрын ХОХБТХэлтсийн мэргэжилтэн |
| | Ш.Ариунболор | ГХБХБГазрын мэргэжилтэн |
| | Г.Мөнхжаргал | Чингис хотын архитектор, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн |

2. “Тэмүүжин хороолол” амины орон сууцны хорооллын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тухай бүр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Чогсомжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

23102001